



МОНГОЛ УЛС  
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 08 сарын 17 өдөр

Дугаар А/439.

Мөрөн сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээ  
шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1 Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3.2, 38 дугаар зүйлийн 38.1, 38.2, 38.4, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, Газрын харилцаа, геодези зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Иргэн Гөрөөчин овгийн Баярмагнайгийн Хаш-Эрдэнэ (РЭ88061734)-ийн хүсэлтийн дагуу аймгийн Засаг даргын 2023 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн А/97 дугаар захирамжаар Мөрөн сум 6 дугаар баг Жаст ойлын хажууд байршилтай 367м2 худалдаа, нийтийн үйлчилгээний газрын зориулалтаар эзэмшүүлсэн 6712017856 нэгж талбарын дугаартай газрыг иргэн Цогнууд овгийн Цагаанчулууны Цолмон (Ц374030304)-д 15 жилийн хугацаатайгаар шилжүүлэн эзэмшүүлсүгэй.

2. Уг захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2023 оны 03 дугаар сарын 10-ны өдрийн А/97 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.

3. Захирамжаар газар эзэмшигч иргэн Цагаанчулууны Цолмонтой газар эзэмших эрх зүйн баталгаажилт хийж, Улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Ганзориг), Улсын бүртгэлийн хэлтэс (Б.Мөнгөнзул) нарт тус тус зөвшөөрсүгэй.

4. Захиргааны актыг ажлын 5 хоногийн дотор эрх, ашиг сонирхол хөндөгдөж буй этгээдэд мэдэгдэж, баримтжуулсан захиргааны актыг хувийн хэрэгт бүрдүүлэлт хийж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Б.Ганзориг)-т үүрэг болгосугай.

5. Аймгийн Засаг даргын захирамжийг эс зөвшөөрвөл захирамжийг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор аймгийн Засаг даргад гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

6. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Б.Батбилгүүн)-д үүрэг болгосугай.

ДАРГА

П.ЛХАГВАЖАВ

6712017856